

“Кодо́мо табунка кёоүсэй төв”-ийн Боловсролын зөвөлгөө өгөх газарт
- түгээмэл ирдэг асуултууд -

【Японы сургуульд элсэн орох талаар】

Асуулт 1.

Хёоүго мужийн олон нийтийн бага(дунд) сургуулиудад элсэн орох ба шилжиж ирэхийн тулд ямар материал бүрдүүлэх хэрэгтэй вэ?

Хариулт 1.

Оршин сууж байгаа хотынхоо боловсролын газрын элсэлт хариуцсан хэлтэсээс зөвлөгөө авч бичиг баримтын бүрдүүлэлт хийнэ үү.

Асуулт 2.

Хёоүго мужийн олон нийтийн ахлах сургуульд элсэн суралцахын тулд ямар материал бүрдүүлэх хэрэгтэй вэ?

Хариулт 2.

Жил бүрийн 3 -р сард явагддаг элсэлтийн шалгалт өгөх хэрэгтэй.

Зарим нэг олон нийтийн ахлах сургуулиудад гадаад хүүхдэд зориулсан элсэлтийн тусгай шалгалт 2 -р сард явагддаг. Олон нийтийн ахлах сургуулийн элсэлтийн шалгалтын мэдээлэл Хёоүго мужийн Боловсролын газрын вэб хуудаст байгаа.

Асуулт 3.

Хёоүго мужийн олон нийтийн ахлах сургуульд шилжин орохын тулд юу анхаарах хэрэгтэй вэ?

Хариулт 3.

Оршин сууж байгаа дүүргийн харьяалалын сургуулиудаас өөрийн орох хүсэлтэй ахлах сургуулиас сонголтоо хийж тухайн сургуультайгаа холбогдож асууна үү.

Сонгож буй ахлах сургуулийн захирал шилжин орох хүсэлтийг чинь хүлээж авбал, элсэлтийн шалгалт өгөх болно. Шилжин орох элсэлтийн шалгалт өгөх өдөр, ямар хичээлээр шалгалт авах шалгалтын агуулга нь сургууль тус бүр ялгаатай тул тухайн сургуулиасаа сайн лавлаж асуугаарай.

Асуулт 4.

Мужийн Ашияа Олон Улсын дунд,ахлах боловсролын сургууль болон Мужийн Олон Улсын ахлах сургуульд элсэх болон шилжин орохын тулд яах хэрэгтэй вэ?

Хариулт 4.

Мужийн Ашияа Олон Улсын дунд,ахлах боловсролын сургуулийн элсэлтийн шалгалт жил бүрийн 2 -р сард явагддаг.Сурагч тус бүрээс ярилцлагын шалгалт,зохион бичлэгийн шалгалт авдаг.

Тус сургуульд элсэхийн тулд хэдэн нөхцөлийг хангасан байх шаардлагатай.Мужийн Ашияа Олон Улсын дунд, ахлах боловсролын сургуулийн вэб хуудаснаас лавлаж үзээрэй.

Мужийн Олон Улсын ахлах сургуулийн элсэлт жил бүрийн 2 -р сард явагддаг тул сонгон шалгаруулалтын элсэлтийн шалгалтанд оролцох шаардлагатай.Дэлгэрэнгүй мэдээллийг Мужийн Олон Улсын ахлах сургуулийн вэб хуудаснаас авна үү.

Шилжин орох гэж байгаа бол тухайн сургууль руу холбогдож лавлан асууна үү.

Асуулт 5

Мужийн ахлах сургуульд гадаад сурагчдад зориулсан тусгай элсэлтийн шалгалт байдаг уу?

Хариулт5

Тийм байдаг. Рэйва 2 оны элсэлтийн шалгалтыг

Мужийн Кобэ Коүхокү ахлах сургууль
Мужийн Ашияа ахлах сургууль
Мужийн Итами Кита ахлах сургууль
Мужийн Какогава Минами ахлах сургууль

Мужийн Гоүдэра ахлах сургууль зэрэг 5 сургуульд тус бүр 3 сурагчийг элсүүлэх орон тоонд элсэлт авч байгаа.

Элсэлтийн шалгалтын мэдээлэл Хёоүго мужийн Боловсролын газрын вэб хуудсанд тавигдсан байгаа.

Асуулт 6

Сурагч өөрийн эх орондоо ерөнхий боловсрол олж авсан хугацаа нь Япон улсын сургалтаас богино хугацаатай байсан бол ахлах сургуульд элсэж чадах болов уу?

Хариулт 6

Гадаадад 9 жил суралцаж төгссөн бол энд элсэлтийн шалгалт өгч болно.

Үүнээс богино тохиолдолд дунд сургууль төгссөнийг батлах дүрмээс хамаарч, дунд сургууль төгссөн сурагчидтай ижил буюу түүнээс дээгүүр түвшний сурлагатай гэж үнэлэгдвэл шалгалт өгч болно. Дэлгэрэнгүй мэдээллийг Хёоүго мужийн Боловсролын газрын ахлах сургууль хариуцсан хэлтэстэй холбогдож авна уу. (Утас: 078-362-9444)

【“Кодомо табүнка кёоүсэй төв”-ийн талаар】

Асуулт 7

Хёоүго мужийн сургуульд төрөлх хэлээрээ туслалцаа авч болох уу?

Хариулт 7

Хёоүго муж нь Японд ирээд удаагүй байгаа сурагчдад төрөлх хэлээр нь туслалцаа өгөхийн тулд тухайн хэлээр ярьдаг Кодомо табүнка кёоүсэй туслагчийг сургуульд томилон ажиллуулдаг. Туслагч томилон ажиллуулах нөхцөл байдаг тул дэлгэрэнгүй мэдээллийг Кодомо табүнка кёоүсэй төвийн вэб хуудас руу орж Кодомо табүнка кёоүсэй туслагч гэсэн хэсгийг уншина уу.

Туслагч авах хүсэлтийг тухайн хүүхдийн сурч буй сургууль нь гаргана.

Асуулт 8

“Кодомо табүнка кёоүсэй туслагч” нь тухайн сурагчид хэрхэн туслах вэ ?

Хариулт 8

Кодомо табүнка кёоүсэй туслагч нь сурагчдад төрөлх хэлээр нь сургуульд суралцахад тохирсон туслалцаа үзүүлэх ба хичээлийг нь төрөлх хэл дээр нь орчуулан өгч, хүүхдийг Японы сургуульд дасан зохицоход туслалцаа дэмжлэг үзүүлдэг.

Асуулт 9

Кодомо табүнка кёоүсэй туслагч нь ямар шалгаруулалтаар сонгогддог вэ ?

Хариулт 9

Туслагч авах шаардлага гарвал шинээр туслагч болох хүсэлтэй хүмүүсээс шалгалт авч сонгон шалгаруулдаг. Шинэ туслагч шаардлагатай тохиолдолд ажлын зар гаргах тул вэб хуудсаар мэдээлэх болно.

Асуулт 10

Кодомо табүнка кёоүсэй сайн дурын ажилтан болохын тулд ямар материал бүрдүүлэх ба хэрхэн бүртгүүлэх вэ ?

Хариулт 10

Кодомо табунка кёоүсэй төвд хэзээ ч бүртгүүлж болно.

Кодомо табунка кёоүсэй төвийн вэб хуудас руу ороод “сайн дурын ажилтны банк” (ボランティアバンク) цэсийг сонгож тэр хуудас дотор байгаа бүртгүүлэх маягыг татан авч бөглөөд Кодомо табунка төв рүү илгээнэ үү.

Асуулт 11

Кодомо табунка кёоүсэй төвд ямар зөвлөгөө өгдөг вэ?

Хариулт 11

Кодомо табунка кёоүсэй төвд гадаад сурагчдын төгсөлт, цаашид дэвшин суралцах талаарх зөвлөгөө болон, япон хэл заах, хичээлдээ яаж суралцах талаар зөвлөгөө өгдөг.

Зөвлөгөө авахаар шийдсэн бол эхлээд төвтэй холбогдоно үү !

Асуулт 12

Кодомо табунка кёоүсэй төвөөс яаж зөвлөгөө авах вэ?

Хариулт 12

Төвийн байранд ирж зөвлөгөө авахаас гадна,

Утас (0797-35-4537) Факс (0797-35-4538)

И-мэйл хаяг (mc-center@hyougo-c.ed.jp), вэб хурлын системийг ашиглаж онлайнаар зөвлөгөө авч болно.

Хэрвээ төвийн байранд ирэх болон онлайнаар зөвлөгөө авах тохиолдолд урьдчилан захиалга өгнө үү.

Асуулт 13

Кодомо табунка кёоүсэй төвөөс зөвлөгөө авах үед орчуулагч авч болох үү?

Хариулт 13

Болно, урьдчилан захиалга өгөх хэрэгтэй.

Асуулт 14

Кодомо табунка кёоүсэй төв нь ямар ч хүнд сургалтын материал зээлдүүлдэг үү?

Хариулт 14

Тийм. Зарчмын хувьд ямар ч хүн зээлдэж авч болно.

Дэлгэрэнгүй мэдээлэлийг Кодомо табунка кёоүсэй төвтэй холбогдож авна үү.

Асуулт 15

Кодомо табунка кёоүсэй төв Бямба,Ням гаригуудад ажилладаг үү?

Хариулт 15

Бямба , Ням гаригуудад болон Амралтын өдрүүдэд амарна.

Ажлын өдрүүдэд 9-17 цагийн хооронд ажиллана.

【Бусад асуултууд】

Асуулт 16

Япон хэл мэдэхгүй учраас хичээлээ бүрэн ойлгож, гүйцэж чадах болов уу гэж санаа зовж байна?

Хариулт 16

Хёоүго мужид бол Японд ирснээс хойш 1 жил, Кодомо табунка кёоүсэй туслагчийг сургуульд томилон төрөлх хэлээр нь хичээлийг нь орчуулан өгч тухайн сургуулийн хичээлүүдэд тохирсон түслалцаа үзүүлдэг. (Хүсэлтийг тухайн хүүхдийн сурч байгаа сургуулиас гаргана.)

Японы сургуульд суралцахын тулд япон хэлний мэдлэг хэрэгтэй учраас бага багаар япон хэлээ сураарай. Кодомо табунка кёоүсэй төвд япон хэл сурахад зориулсан сургалтын материал ном сурах бичиг байгаа тул зээлдэн авч хэрэглэж болдог .

Мөн Хёоүго мужийн олон улсын харилцааны нийгэмлэгийн вэб хуудсанд дүүрэг тус бүрт хичээллэж буй япон хэлний сургалтуудыг танилцуулсан байгаа. Дүүрэг тус бүрт явагдаж буй япон хэлний сургалтанд хамрагдах боломжтой. Бэрхшээлтэй зүйл тулгарвал санаа зоволтгүйгээр багш нартайгаа ярилцаж зөвлөгөө аваарай.

Асуулт17

Япон хэлийг хаана сурах вэ?

Хариулт17

Хёоүго мужийн олон улсын харилцааны нийгэмлэгийн вэб хуудсанд дүүрэг тус бүрт хичээллэж буй япон хэлний сургалтуудыг танилцуулсан байгаа.